



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/360

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.3, 3.4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймаг, Аллиер муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Франц улсын Аллиер мужид 2023 оны 07 дугаар сард зохиогдох олон улсын Ганнат фестивалд аймгийн Хөгжимт драмын театрын 11 төлөөлөгчийг оролцуулсугай.

2. Тус фестивалд оролцогчдын замын зардалд нийт 49,500,000 (дөчин есөн сая таван зуун мянга) төгрөг зарцуулагдахаас Монгол Улсын Соёлын яам 20,000,000 (хорин сая) төгрөгийг санхүүжүүлэх бөгөөд зардлын үлдэгдэл 29,500,000 (хорин есөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0696

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар
сарын 27-ны өдрийн 11/30 дугаар
захирамжийн хавсралт



ОЛОН УЛСЫН ГАННАТ ФЕСТИВАЛД ОРОЛЦОХ АЙМГИЙН
ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН 11 ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ЗАМЫН ЗАРДАЛ

Улаанбаатар-Парис-Улаанбаатар чиглэлийн нислэгийн нийт
зардал=11x4,500,000=49,500,0000 төгрөг

№	Зардлын төрөл	Тоо	Нийт
1	Улаанбаатар-Парис- Улаанбаатар чиглэлийн нислэгийн зардал	11 хүн	29.500.000
Нийт			29.500.000

-oOo-